

1272 ОНЫ НУР АД-ДИНИЙ БИЧГИЙН ЗАРИМ ОНЦЛОГ

М. Ууганбаяр*

Кыршехирийн ноён Нур ад-Дин бин Жажаоглу 1272 онд Анатолийн хойгийн янз бүрийн хэсэгт оршиж байсан өөрийн эдлэн газар, орд харш, өв хөрөнгөө үр ач нартаа, түүнчлэн лалын сүм хийд, дацан, албан хэргийн газар хийгээд бусад байгууллагад сан болгон үлдээхдээ сангийн удирдан зохицуулахтай холбоотой хүсэл саналаа араб монгол хоёр хэлээр бичүүлжээ. Энэ сангийн бичгийн араб хэлээрх хэсэг нь Жажаоглугийн бүх өмч хөрөнгийг нэгд нэгэнгүй дурдсанаараа хэмжээний хувьд том харин монгол хэлээрх хэсэг нь зөвхөн Анатолийн хойг дахь Монгол Ил хаадын удирдагчдаар баталгаажуулах зорилготой байсан тул хэмжээ дамжаа бага байгаа ажээ. Жажаоглу Нур ад-Диний вакфиеэ юм уу сангийн бичгийн монгол хэлээрх хэсэг нь гурван тусдаа эх бичиг буюу I А 61, I В 6, II 9 нийт 78 мөрөөс бүрдэнэ. Энэ гурван монгол эх бичгийн талаар Ф Көпрүлү, II Пеллио, Р Рахмети Арат, А. З. В. Тоган, Г. И. Рамстедт, Ф В Кливез, Н Фрай зэрэг олон эрдэмтэн мэдэж байсан ч анх удаа хамгийн дэлгэрэнгүй судалсан хүн нь А. Темир бөгөөд А. Темирийн галигт тулгуурлан Л. Лигети дахин шинээр галигласан байдаг(Темир 1989: 327-329, Лигети 1972: 270-274).

Бид нэлээд хэдэн жилийн өмнө профессор А.Темирийн дараа энэхүү сангийн бичиг буюу сонгодгоос өмнөх онд үеийн монгол бичгийн хэлний үнэтэй дурсгалыг судалж шинээр галиглан орчин цагийн монгол хэлээрх орчуулга, үгийн тайлбар, хэлхээсийн хамт хэвлүүлсэн билээ (Ууганбаяр 2003: 244-265).

Бид энэ удаа 1272 оны Нур ад-Дин Жажаоглугийн сангийн бичгийн хэлний онцлог тухайлбал монгол хэлний олон тооны үг бичлэг хэлбэрийн болоод утга агуулгын талаас ихээхэн өвөрмөцөөр хэрэглэгдсэн байдлыг тодруулан зарим нэгэн жишээг үзүүлэхээр шийдлээ.

Эл дурсгалд зарим үгийг өвөрмөцөөр бичсэн баримтаас дурдахад, тухайн үеийн ярианы хэлний байдлыг тусгасан хэлбэр тааралдаж байна. Монгол бичгийн хэлний “egüdeci” хэмээх үгийг бидний авч үзэж байгаа дурсгалын IA 37 айдеci (Темир 1989:328). хэмээн бичсэн бөгөөд Л.ба Кир.-д eüden, “evdarč” гэх мэт хэлбэрээр тохиолдох энэ үг монгол хэлний урт эгшгийг судлахад сонин жишээ болж мэднэ. (Поппе 1927:1259, 1261). Харин Л.Лигети үүнийг “Eçudeci” гэх хүний нэр хэмээн үзжээ. (Лигети 1972:272)

* Монгол Улсын Их Сургууль, Монгол Хэл Соёлын Сургууль

Энэ дурсгалын IA 9 II 5 мөрнөө монгол бичгийн хэлний qoüin-a-г qoüina гэж бичсэн нь (Темир 1989: 327, 329) тухайн үеийн аман ярианы хос эгшгийг тусган тэмдэглэсэн хэрэг биз. Сул.12v7 мөр, Түрфаны дурсгалын хүнлэг сайн явдлыг сургасан гар бичмэл сургаал шүлэгт qoüin-a (Кливез 1959:40,44., Поппе 1927:264) Араб үсгээр тэмдэглэсэн Л. Му. Им. qoüina гэж гарна (Поппе 1928:65, 1938: 300)

Энэхүү дурсгалд зарим үгийн эхний э эгшгийг а -аар бичсэн байна.

Эл бичгийн 9. мөрнөө ene гэсэн үгийг заримдаа сонгодог монгол бичгийн өмнөх дурсгалуудад гардаг шигээр “ane” гэсэн хэлбэрээр (Кливез 1959:46, Темир 1989:172, Лигети 1972:270). ebügen хэмээх үгийг 1305 оны Өлз.7.14.33. мөрнөө (Мостаерт, Кливез 1962:55,56), Сул. 12г.9-10 мөрнөө (Кливез 1959:51) тус тус тохиолддог шиг “abügen” гэсэн хэлбэрээр (Темир 1989:328, Лигети 1972:271) бичжээ. Энэхүү дурсгалын IA 35 мөрнө гарах Asen (Темир 1989:328, Лигети 1972:271) гэх үгийн уугуул хэлбэр нь “Esen” бөгөөд угтаа Тү.Мо. “esen” (энх, эсэн)-ээс үүссэн байна.

Энэхүү дурсгалын IA 9. мөрнөө бас л сонирхолтой үг тааралдаж байна. Эл /m/ö/nü qoüina холбоо үгийг А Темир minu qoüina хэмээн галиглаад миний хойно надаас хойно хэмээн түрэг хэлнээ хөрвүүлсэн нь энэхүү үгийн дээд хэсэг баларсантай холбоотой байж болох бөгөөд Л Лигети ч А. Темирийг дагажээ . (Темир 1989: 327, 329, Лигети 1972: 270)

Бидний бодлоор энэхүү үг ардахь хойно хэмээх үгтэйгээ хамт “одоо ирээдүйд” гэх утгыг заах ба сонгодгоос өмнөх монгол бичгийн хэлний дурсгал буюу тухайлбал 1335 оны Чанг-Йин-Жүйн хөшөөний бичгийн 47. Мөр, 1362 оны Индү вангийн хөшөөний бичгийн 29. мөрнөө гарч буй Каракийн Сайф ад-Диний бичгийн 2. Мөрнөө гарч буй (Кливез 1953а: 483, Амби 1962:146) топа qoüina -ийн нэг хувилбар бололтой. Энэ үг хятад үсгээр бичигдсэн дундад зууны монгол хэлний дурсгал болох Монголын нууц товчооны 187, 231, 225 зүйлд топе qoüina 93, 208, 220, 246 зүйлд топнó qoüina (Дашцэдэн 1985: 121, 169, 38, 154, 181), Хуа-И-И-Юй толийн хавсралт хятад монгол харилцааны бичгийн b23v- топо qoüina (Хэниш 1952: 26), Стамбулийн дөрвөлжин үсгийн зарлигт 2. мөрнөө топа qoüina янз бүрийн хэлбэрээр тохиолдоно(Жанчив 1997: 56-58)

Эл бичгийн I A 10. мөрөнд гарах jige köbegün хэмээх холбоо үгийн jige зээ-г А Темирээс уеке их гэж үзсэн нь ташаарал юм. (Темир 1989 327) 6 Түүний ингэж ойлгоход эх бичигт буй алдаатай хуулбар нөлөөлсөн бололтой. Л Лигети уеке köbegün (Лигети 1972 270, 274) хэмээн галигласан нь ч бас буруу юм. Хожим хийсэн оруулга үг тул jige хэмээх үг köbegün гэх үгийн өмнө байрлана. Эл холбоо үг юуны өмнө утгын талаас ихээхэн өвөрмөц, монгол бичгийн хэлний дурсгалд ер тохиолддоггүй нь сонирхолтой байна Хөвүүн гэх үг эрт цагт хүүхэд гэсэн утгатай байсан бөгөөд Монголын нууц товчооны 65. зүйлд гарах Nugun köbüd manu nuntug qarayu ökin köbüin manu öngge üjegdeyu (Дашцэдэн 2009:31)

Нуган хөвүүд ману

Нутаг харьюу

Охин хөвгүүн ману

Өнгө үзэгдьюү (Чоймаа 2011: 28) хэмээх жишээнд буй нуган хөвгүүн охин хөвүүн гэдэгтэй адил байдлаар бидний авч ярьж буй энэ дурсгалд зээ хөвүүн юм уу зээ хүү гэж бичсэн байж болох бөгөөд одоо цагт монгол хэлнээ хүргэн хүү гэх холбоо үг хэрэглэгддэг нь ч дээрх лүгээ холбоотой ажээ. Ташрамд дурдахад түрэг хэлнээ ч яг иймэрхүү маягаар холбоо үг үүсдэг билээ. Эртний түрэг хэлний дурсгал болох 732 оны Келтигиний хөшөөний бичгийн зүүн 7. мөрнөө (Эргин 1996: 68) Tabgaç budunka beglik uri oglin kul boldi, ipilik kiz oglin küng boldi “Хятад улст эрэлхэг эрэгтэй хөвүүдээ боол болгож гоолиг охин хөвүүдээ шивэгчин болгов”

гэх, 735 оны Билгэ хааны хөшөөний бичгийн зүүн 7. мөрнөө (Эргин 1996:78) *Tabgaç budunka beglik uri oglin kul kilti ipilik kiz oglin kúng kilti* “Хятад улст эрэлхэг эрэгтэй хөвүүдээ боол болгож гоолиг охин хөвүүдээ шивэгчин болгов” гэх баримтад тохиолдох *uri oglin* буюу эр хөвүүн *kiz oglin* буюу охин хөвүүн тэргүүтэн жишээг харж болно.

Энэ бичгийн I A 15. мөрнөө *qaltuγai* хэмээх үг тохиолдож буйн тухайд, Тег. III. 30-1 мөр Тур. U 5981. 10. мөрнөө “довтлох доромжлох гомдоох гэх утгаар орсон эл үгэнд “ойртох хүрэх дөхөх” гэсэн бас нэг утга байсан болохыг МНТ 201. зүйлд гарах *qalidun* гэх жишээ хийгээд (Ууганбаяр 1996: 78) Хал. хал “ойртох дөхөх” халмаг “халж ирх”, ЭМо. *Qalu- Ma.хал-па Саг. калан* (Рамстедт 1935: 162) Нан. Ульч хэлнээ халачи “ойртох” кал “ойр дотно дөхүү” калчи Орок халагчи кал Орч. алач Үдэ. аласи Сол. алаши Эв. Эве. Нег. алат/и/, Нан.алама, алча хүлээх, Ма.карна “ойртох зэрэгцэх, уулзах, угтах” Мо.кала калу, ЭТү кал, Бшк.коли, Алт, Кыр, Тат, Тув, Хак, Үзб. хал хол, Түркм, Аз.гол ТТү. кал Чүв.йүл (Цинциус 1984:81) баталж нотолж болох юм. Иймээс эл үгийг А Темир шиг хор бүү хүргэгтүн гэх нь ташаа болно.

Бидний авч ярьж буй эх бичгийн I A 15. 16. мөрнөө таарах *buši buu bolγatuγai buši bolγabasu* гэх холбоо үгийг А Темир Монголын нууц товчооны 203 зүйлд гарах *činu úge buši bu bolγatuγau* (Темир 1989:155) хэмээсэн жишээг үгээс чинь өөрөөр бүү яваг гэж ойлгоод бидний авч ярьж буй сангийн бичгийн дээрх холбоо үгийг өөр хэлбэрт бүү аваачигтун бүү өөрчлөгтүн хэмээн түрэг хэлнээ буулгажээ. Мөн Ц Дамдин сүрэн 1305 оны Өлзийт султаны бичгийн 16. мөрнөө буй энэ хэллэгийг орчин цагийн монгол хэлэнд “үл өөрчлөн” гэж хөрвүүлсэн байна (Дамдинсүрэн 1957:39-40) Гэтэл бид Монголын нууц товчооны эх бичгээс харахад энэ хэллэг нь харин ч үл зөрчих үл тэрслэх гэсэн утгатай байгаа тул бид зөрчих гэж ухаж буй бөгөөд А Мостаэрт Ф. В. Кливез нар ч энэхүү холбоо үг монгол бичгийн хэлний болоод дундад зууны монгол хэлний олон дурсгалд зөрчих гэсэн утгаар гардгийг тогтоосон ажээ.(Мостаэрт Кливез 1952: 464, 1962:55,56, Кливез 1953 б 26-32, 35)

Энэхүү дурсгалын I A 22. 61. мөрнөө гарах *gere bolbai I B 6. мөрнөө* тохиолдох *gereci belge* зэрэг баримтанд буй гэсэн хоёр үг нь мөн л монгол хэлнээ ер үл хэрэглэгдэх утгыг өөрөөр хэлбэл *gere* нь орчин цагийн монгол хэлний гэрч гэх утгыг *gereci* нь орчин цагийн монгол хэлний гэрээ бичиг гэх утгыг заах нь ихээхэн сонирхолтой юм. Харин Хар хотоос олдсон гэрээ бичигт *gereci* нь орчин цагийн монгол хэлнийх лүгээ адилаар гэрч *gere* гэрээ бичиг гэсэн утгыг илтгэдэг ажээ. (Кливез 1955:43, Цэвэл 1966: 170,171)

Энэхүү сангийн бичигт цэргийн болоод бусад олон чухал нэр томъёо тохиолдож байгааг анхаарах хэрэгтэй юм. Тухайлбал уул дурсгалын IA 26. мөрнөө гарах *tudγayul* хэмээх цэргийн нэр томъёо (Темир 1989:328, Лигети 1972:271) хэд хэдэн хэл аялгуу бичгийн дурсгалд тэмдэглэгдэн үлдэж хэлбэр утгын аль аль нь багагүй хувирч өөрчлөгджээ. Уул үгийг Г.Дёрфер Тү. *tut-* (барих) үйл үг, Монгол *-ga* (дагавар)- аас бүтсэн *tutga-* “хөл барих, саад болох”, Мо. *todqar* “саад, тотгор” зэрэг үгээс илрэлтэй гэж үзэж, (Дёрфер 1963:124) В.Банг Мо. *tutg-*үйл үг нь авиа тонгорохын хуулиар *togta-* (тогта-) болсон хэмээн тайлбарлажээ. (Банг 1919:56-57). Харин Ш.Цэцэнцогт, М.Базаррагчаа нар *todqagul-*ийг мөн л Мо. *torqu-*”-тай гарал нэг хэмээгээд Мо. *torqu* “торох, тээглэх”, *tosqu* “тосох”, *totuqu* “хаалганы дээрх хөндлөн мод”-ийн *r,s,t* авиа нь “d”-ээр сэлгэж “*todqu*” нь үүссэн гэх санал дэвшүүлсэн аж. (Цэцэнцогт 1988:1934-1937, Базаррагчаа 1994:57, 277) 1267 оны Аб.9. мөрнөө тохиолдох уг үг мөн тэр үеийн Монголын их гүрний дорно хэсэгт *totgasun* гэсэн хэлбэрээр хэрэглэгдэж байжээ. (Мостаэрт, Кливез 1952:436-437, Дёрфер 1963:253). Энэ дурсгалын IA 34. 58. мөрнөө гарах *bökeγül* (Темир 1989:328, Лигети 1972:271) цэргийн нэр томъёо нь төрөл бүрийн хэл аялгуу, бичгийн дурсгалд тархаж, хэлбэр

М. Ууганбаяр

утгын хувьд ч хэдэн янзаар хувирсан ба судлаачид хэл, түүхийн талаас шинжилж цөөнгүй санаа оноо гаргажээ. Уул үгийг Г.Дёрфер “цэргийн харуул” гэсэн утгатай гэж үзээд Тү. *bü*- үйл үгнээ Мо. *-gul/vul* дагавар залгаж үүссэн хэмээв. (Дёрфер 1965:301-307). Эл *bök*-ийг зарим хүн монгол хэлнээс түрэг хэл рүү орсон үг гэх нь ч бий бөгөөд (Кларк 1968:132-133) үнэхээр ч монгол болоод манж, түнгүс хэлнээ тохиолдоно. (Ууганбаяр 1996:38, ССТМ 1975:102). *Bökegüi*-ийг Монголын их гүрний дорно хэсэгт *bökesün* хэлбэрээр хэрэглэж байсан нь хятад үсгээр тэмдэглэгдэн үлджээ. (Кливез 1964:164-175)

Энэ дурсгалын IA 30. мөрнөө гарах *boranud*- А.Темир Ар. *berhaniye* (ордныхон, ордны бараа бологчид) лүгээ холбосон (Темир 1989:169) эл үг бидний саналаар Уйг. “*boron*” (урьд дээдэс) Мо. *buruqai* (*boron-aqai*) (урьдас дээдэс) болон *-ud* (олон тооны дагавар)-аас бүтсэн “өвгөдийн ноён, өтгөсийн ноён” эх үг байж магадгүй юм.

Эл дурсгалын IA 22. мөрнөө гарах *pöker*- энэ нь “ноёны хиа, туслагч” гэх зэрэг утгаар тэр цагийн нийгмийн тодорхой бүлгийн нэр, цол болж хэрэглэгдэж байсан үг юм. (Темир 1989:168). Одоогийн хэлбэр нь *pökür* болно. Уул үгийн гарал утгын талаар Б.Я.Владимирцов, Г.Дёрфер, Базаррагчаа нарын судалгаанаас үзэж болно. (Б.Я.Владимирцов 1923:305 -341, Дёрфер 1963, 388, Базаррагчаа 1994:261-263)6

Энэхүү дурсгалын IB 2. Мөрнөө гарах *seced-ün inu tula* гэсэн хэллэгийг А.Темир *haurat icin* (сайн үйлийн тул) (Темир 1989:165) гэж ойлгосон нь буруу юм. Сангийн үйл ажиллагаанд оролцож буй ноёдыг магтан хүндэтгэж “цэцэд болохын учир” хэмээн дурьдаж байгаа нь эх бичгээс илэрхий байна. “Цэцэн” гэдэг үгийг монгол хэлэнд “Жамуха цэцэн, Мандухай цэцэн” гэхчилэн хүндэтгэлийн утгаар хэрэглэдэг уламжлалаар энд язгууртан сайд нарыг “сэцэд” хэмээн нэрлэсэн нь сонин юм.

Энэ сангийн бичигт хүний нэр зарим ажил албын нэр мөн л өвөрмөц онцлогтой хэрэглэгдсэнийг анхаарахгүй орхиж боломгүй билээ.

Ном зүй

1. Базаррагчаа 1994: М Базаррагчаа Монгол үгийн гарлыг мөшгих нь III-IV дэвтэр Улаанбаатар, 1994
2. Дамдинсүрэн 1957: Дамдинсүрэн Ц. Монголын уран зохиолын тойм, 1. 13-16-р зууны үе. Улаанбаатар, 1957.
3. Дашцэдэн 1985: Дашцэдэн Т., Монголын нууц товчооны галиг Улаанбаатар 1985
4. Дашцэдэн 2009: Дашцэдэн Т., Монголын нууц товчооны галиг Улаанбаатар 2009
5. Жанчив 1997: Жанчив Ё., Стамбулын их сургуулийн музей дэх дөрвөлжин үсгийн дурсгал, МУИС, МСДС, ЭШБ, № 9 (126), Улаанбаатар, 1997, 56-61
6. Поппе 1938: Поппе Н. Н. Монгольский словарь Мукаддимат ал-Адаб. М.-Л., 1938. Ч. I-II. Ууганбаяр 1996: Ууганбаяр М., Монголын нууц товчооны зарим үг хэллэгийн тайлбар 1, Улаанбаатар, 1996
7. Ууганбаяр 2003: Ууганбаяр М., Кыршехирийн ноён Жажагийн хөвгүүн Нур Ад-Диний бичгийн тухайд”, “МУИС-ийн Монгол Судлалын Эрдэм шинжилгээний бичиг”, №20 (194) Улаанбаатар , 2003, 244-265
8. Цинциус 1984: Цинциус В.И. Этимологии алтайских лексем с анлаутными придыхательными смычными губно-губным *п` и заднеязычным *к`, Алтайские этимологии. Л., 1984.
9. Цэвэл 1966: Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. Улаанбаатар, 1966.
10. Чоймаа 2011: Чоймаа Ш., Монголын нууц товчоо, Эртний үг хэллэгийн тайлбартай шинэ

М. Ууганбаяр

хөрвүүлэг, Улаанбаатар, 2011

11. Амби 1962: L Hambis La lettre mongole de gouverneur de Karak AOH 15:143-146
12. Банг 1919: W Bang Vom Kokturkischen zum Osmanlischen Berlin 1919
13. Дёрфер 1963: Doerfer G. Türkische und Mongolische Elemente im Neupersischen. Band I Wiesbaden 1963
14. Дёрфер 1965: Doerfer G. Türkische und Mongolische Elemente im Neupersischen Band II Wiesbaden 1965
15. Эргин 1996: Ergin M Orhun Abideleri Istanbul 1996
16. Кливез 1949: Cleaves F. W., The Sino-Mongolian inscription of 1362 in memory of prince Hindu, HJAS, 1949.13,
17. Кливез 1950: Cleaves F. W., The Sino-Mongolian inscription of 1335 in memory of Chang-Ying-iui, HJAS, 13, 1950.
18. Кливез 1953: Cleaves F. W., The Mongolian Documents in the Musee de Teheran HJAS 1953, 16: 1 -107
19. Кливез 1955: Cleaves F. W., An early mongolian loan contract from Qara Qoto, HJAS 1955, 18: 1-49.
20. Кливез 1959: Cleaves, F.W., An Early Mongolian Version of the Alexander Romance. HJAS 1959, 22:1-99
21. Лигети 1971: Ligeti L., Fragments mongols des Berlin AOH 24 : 139-164.
22. Лигети 1972: Ligeti L. Monuments preclassiques. 1. XIII e et XIV e siecles. Budapest, 1972
23. Мостаэрт Кливез 1952: Mostaert A., Cleaves F. W. Trois documents mongols des Archives Secretes Vaticanes, HJAS. 1952 , 15: 419-506
24. Мостаэрт Кливез 1962: Mostaert, Cleaves 1962 - Mostaert A., Cleaves F. W. Les lettres de 1289 et 1305 des ilkhan Argun et Oljeitu a Philippe le Bel. Cambridge, Mass., 1962.
25. Поппе 1928: Poppe N., "Das mongolische Sprachmaterial einer Leidener Handschrift.", Известия Академии наук СССР. 1928: 55-80
26. Поппе 1960: Poppe N., Ein mongolisches Gedicht aus den Turfan-Funden, CAJ, 1960 4: 257-294
27. Рамстедт 1960: Ramstedt G. J. Kalmukisches Wörterbuch. Helsinki, 1935.
28. Темир 1989: Temir A., Kırşehir emiri Caca oğlu Nur el-Din'in 1272 tarihli Arapça-Moğolcavakîyesi, Türk Tarih Kurumu Basımevi Ankara, 1989
29. Хэниш 1952 : E Haenisch Sino-mongolische Dokumente vom Ende des 14. Jahrhunderts Abh. Adw.zu Berlin Jg 1950:4 Berlin
30. Цэцэнцогт 1988: Sečencöoytu Monggyul uges-un ijaar un toli Jangjia Keu 1988

Товчилсон үгс

- Аб. Абага ханы бичиг
- Ар. Араб хэл
- Аз. Азербайжан хэл
- Бур. Буриад аялгуу
- Бшк. Башкир хэл
- Газ. Газан ханы бичиг
- Им. Ибн ал-Муханны толь
- Ин. Инду вангийн хөшөөний бичиг
- Кир. Киракосын тэмдэглэл
- КМҚВ. Хятад монголын харилцааны бичиг
- КСайф. Каракийн Сайф ад-диний бичиг
- Кыр. Кыргыз хэл
- Л. Лейдэний толь

Ма. Манж хэл
МНТ. Монголын нууц товчоо
Мо. Монгол хэл
Му. Мухаддимат ал-Адаб толь
Нан. Нанай хэл
Нег. Негидал хэл
Ор. Ороки аялгуу
Оро. Орочи аялгуу
Өлз. Өлзийт ханы бичиг
Пе. Перс хэл
Саг. Сагай аялгуу
Сам. Самгарди хэл
СДЗ. Станбулын дөрвөлжин үсгийн зарлиг
Сол. Солон хэл
Сул. Сулхарнайн тууж
Тат. Татар хэл
Тег. Тегераны музей дахь бичиг
Тркм. Туркмен хэл
ТТү. Түргийн түрэг хэл
Тув. Тува хэл
ТХлх. Төв халхын аман аялгуу
Тү. Түрэг хэл
Увайс. Увайс баатар ханы бичиг
Үд. Үдегей хэл
Үзб. Узбек хэл
Үльч. Ульч хэл
Хак. Хакас хэл
Хал. Халимаг аялгуу
Ху. Хуа-И-И-Юй толь
Хят. Хятад хэл
Чув. Чуваш хэл
Эв. Эвенк хэл
Эве. Эвен хэл
ЭМо. Эртний монгол хэл
ЭТү. Эртний түрэг хэл

Summary

The Letter of Nur el-Din

In this brief article author discusses on some peculiarities the vakfiye or letter of Nur el-Din bin Cacaoglu.

Cacaoglu the emir of Kirsehir in Anatolia in the time of ruling Mongolian Ilkhanidian state had left vakfiye or the letter of foundation on his estates and properties in Arabic and Mongolian. Mongolian part of this letter, which had written in 1272 is a monument of the preclassic written Mongolian. As one of the preclassic written Mongolian monument, in the letter of Nur el-Din occur several words and expressions that from the aspects of writings and meanings might be interesting. For example, Mongolian complex word jige kobegun in this letter no means 'nephews and sons' as precedent scholars had considered but only 'nephews and children'. In Mongolian word kobegun and in Turkish word ogul mean 'child or kid'. On this occasion, in Mongolian and Turkish we encounter many facts such as 'oki kobun, nugun kobun, kiz oglin, uri oglin'